



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/183/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn
Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: "Гийк Ом Аудит"
Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10-11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11-12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12-14
4. Аудитын тайлан	15-18
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15-16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16-17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17-18
5. Аудитын илрүүлэлт	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	18-19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НДШ	Нийгмийн даатгалын шитгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**АЛТАНБУЛАГ СУМЫН
3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ У.ТЭРГҮҮНБАЯР
ТАНАА**

2025.02.25 № СЭА-2025/183/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 16,979.4 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус цэцэрлэгийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 89.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>/төгрөгөөр/</i>			
Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	79,690,536.71	78,787,176.95
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	61,166,810.31	57,191,847.55
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	61,166,810.31	57,191,847.55
3121	Төгрөг	61,166,810.31	57,191,847.55
31211	Төрийн сангийн харилцах	61,166,810.31	57,191,847.55
33	АВЛАГА		
35	БАРАА МАТЕРИАЛ	18,523,726.40	21,595,329.40
354	Хангамжийн материал	18,523,726.40	21,595,329.40
3541	Бичиг хэргийн материал	56,500.00	170,450.00
3542	Аж ахуйн материал	16,660,954.40	18,080,254.40
3544	Түлш, шатах тослох материал	1,256,000.00	2,944,000.00
3546	Хүнсний материал	550,272.00	400,625.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	675,774,855.13	675,910,214.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	675,774,855.13	675,910,214.74
392	Биет хөрөнгө	675,748,813.61	667,776,589.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	697,041,022.00	697,041,022.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-38,724,501.20	-50,341,851.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,802,828.30	39,717,328.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	-21,817,724.17	-26,281,669.53
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,124,282.50	7,124,282.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,343,760.40	-3,149,188.52
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,333,333.42	-6,333,333.46
393	Биет бус хөрөнгө	26,041.52	8,133,625.01
39301	Програм хангамж	1,250,000.00	2,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,223,958.48	-1,334,374.99
39303	Бусад биет бус хөрөнгө		7,318,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	755,465,391.84	754,697,391.69
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	755,465,391.84	754,697,391.69
51	Засгийн газрын хувь оролцоо	755,465,391.84	754,697,391.69
512	Хуримтлагдсан үр дүн	755,465,391.84	754,697,391.69
5121	Өмнөх үеийн үр дүн	755,465,391.84	755,465,391.84
5122	Тайлант үеийн үр дүн		-768,000.15
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	755,465,391.84	754,697,391.69

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			<i>/төгрөгөөр/</i>
Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	302,126,535.21	412,116,635.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		7,318,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		7,318,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		7,318,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	302,126,535.21	404,798,635.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	283,586,600.00	373,459,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	283,586,600.00	373,459,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		10,056,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,056,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,539,935.21	21,282,635.48
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,539,935.21	21,282,635.48
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	288,410,805.04	412,884,635.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	288,410,805.04	412,884,635.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	288,410,805.04	412,884,635.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	192,958,955.00	304,220,200.00
210101	Үндсэн цалин	142,202,180.00	198,459,358.00
210102	Нэмэгдэл	41,315,209.00	93,834,687.00
210104	Урамшуулал	9,441,566.00	11,926,155.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,718,697.69	37,887,017.76
210201	Тэтгэврийн даатгал	17,389,123.69	25,929,414.76
210202	Тэтгэмжийн даатгал	2,030,574.00	2,999,415.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,838,951.00	1,493,191.00
210204	Ажилгүйдлийн даатгал	398,901.00	1,394,263.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,061,148.00	6,070,734.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,934,375.21	16,126,835.48
210301	Гэрэл, цахилгаан	4,395,737.91	5,130,835.48
210302	Түлш, халаалт	8,918,637.30	9,376,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,620,000.00	1,620,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		476,500.00
210401	Бичиг хэрэг		56,500.00
210408	Бараа материал акталсны зардал		420,000.00
2105	Нормативт зардал	22,095,047.00	24,572,232.00
210502	Хоол, хүнс	22,095,047.00	24,572,232.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,091,000.00	1,871,300.00
210604	Урсгал засвар	3,091,000.00	1,871,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	480,000.00	891,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	480,000.00	891,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,132,730.14	26,839,550.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,791,573.00	4,460,420.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	783,755.00	2,633,990.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,557,402.14	19,745,140.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	13,715,730.17	-768,000.15
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	13,715,730.17	-768,000.15

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

<i>/төгрөгөөр/</i>			
Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	302,126,535.21	404,798,635.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	302,126,535.21	404,798,635.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	283,586,600.00	373,459,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	283,586,600.00	373,459,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		10,056,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,056,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,539,935.21	21,282,635.48
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,539,935.21	21,282,635.48
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	266,132,612.90	396,211,098.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	266,132,612.90	396,211,098.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	266,132,612.90	396,211,098.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	192,958,955.00	304,220,200.00
210101	Үндсэн цалин	142,202,180.00	198,459,358.00
210102	Нэмэгдэл	41,315,209.00	93,834,687.00

210104	Урамшуулал	9,441,566.00	11,926,155.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,718,697.69	37,887,017.76
210201	Тэтгэврийн даатгал	17,389,123.69	25,929,414.76
210202	Тэтгэмжийн даатгал	2,030,574.00	2,999,415.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,838,951.00	1,493,191.00
210204	Ажилгүйдлийн даатгал	398,901.00	1,394,263.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,061,148.00	6,070,734.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,070,935.21	17,814,835.48
210301	Гэрэл, цахилгаан	3,373,526.00	5,130,835.48
210302	Түлш, халаалт	10,617,409.21	11,064,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,080,000.00	1,620,000.00
2105	Нормативт зардал	20,889,875.00	24,422,585.00
210502	Хоол, хүнс	20,889,875.00	24,422,585.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,469,000.00	3,467,800.00
210604	Урсгал засвар	3,469,000.00	3,467,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	497,700.00	891,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	497,700.00	891,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,527,450.00	7,507,660.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,960,695.00	4,752,670.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,566,755.00	2,754,990.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	35,993,922.31	8,587,537.24
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,551,000.00	12,562,500.00
	Дотоод эх үүсвэрээр	1,551,000.00	12,562,500.00
222001	Тоног төхөөрөмж	1,551,000.00	12,562,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,551,000.00	-12,562,500.00
145	Бусад эх үүсвэр		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	34,442,922.31	-3,974,962.76
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		61,166,810.31
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		57,191,847.55

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			755,465,391.84	755,465,391.84
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Тайлант үеийн үр дүн			-768,000.15	-768,000.15
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			754,697,391.69	754,697,391.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	467,355,600.00	408,773,598.24	58,582,001.76	87.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	467,355,600.00	408,773,598.24	58,582,001.76	87.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	467,355,600.00	408,773,598.24	58,582,001.76	87.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	347,594,000.00	304,220,200.00	43,373,800.00	87.5
210101	Үндсэн цалин	227,645,400.00	198,459,358.00	29,186,042.00	87.2
210102	Нэмэгдэл	114,178,600.00	93,834,687.00	20,343,913.00	82.2
210104	Урамшуулал	5,770,000.00	11,926,155.00	-6,156,155.00	206.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,321,100.00	37,887,017.76	3,434,082.24	91.7
210201	Тэтгэврийн даатгал	28,098,900.00	25,929,414.76	2,169,485.24	92.3
210202	Тэтгэмжийн даатгал	3,305,200.00	2,999,415.00	305,785.00	90.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,652,800.00	1,493,191.00	159,609.00	90.3
210204	Ажилгүйдлийн даатгал	1,652,800.00	1,394,263.00	258,537.00	84.4
210205	Эрүүл мэндийн даатгал	6,611,400.00	6,070,734.00	540,666.00	91.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,202,800.00	17,814,835.48	1,387,964.52	92.8
210301	Гэрэл, цахилгаан	6,493,800.00	5,130,835.48	1,362,964.52	79.0
210302	Түлш, халаалт	9,739,000.00	11,064,000.00	-1,325,000.00	113.6
210303	Цэвэр, бохир ус	2,970,000.00	1,620,000.00	1,350,000.00	54.6
2104	Хангамж, бараа материалын зардал				
2105	Нормативт зардал	33,565,900.00	24,422,585.00	9,143,315.00	72.8
210502	Хоол, хүнс	33,565,900.00	24,422,585.00	9,143,315.00	72.8

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,526,500.00	13,524,300.00	2,200.00	100.0
210604	Урсгал засвар	13,526,500.00	13,524,300.00	2,200.00	100.0
2107	Томилолт, зочны зардал				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	983,800.00	983,800.00		100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	983,800.00	983,800.00		100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,161,500.00	9,920,860.00	1,240,640.00	88.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,406,300.00	7,165,870.00	1,240,430.00	85.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,755,200.00	2,754,990.00	210	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
2132	Бусад урсгал шилжүүлэг				
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ				
	Дотоод эх үүсвэрээр				
222001	Тоног төхөөрөмж				
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	467,355,600.00	404,798,635.48	62,556,964.52	86.6
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	444,682,800.00	383,516,000.00	61,166,800.00	86.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	373,459,500.00	373,459,500.00		100.0
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	61,166,800.00		61,166,800.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,056,500.00	10,056,500.00		100.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,056,500.00	10,056,500.00		100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,672,800.00	21,282,635.48	1,390,164.52	93.9
132001	Орон нутгийн төсвөөс	22,672,800.00	21,282,635.48	1,390,164.52	93.9
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС				
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		61,166,810.31	-	61,166,810.31
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		57,191,847.55	-	57,191,847.55

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэг нь “Бид ажилдаа сэтгэл гарган мэндлэх, хүндлэх, талархалыг эрхэмлэн, багш, ажилтан хүүхдийн хөгжилд ахиц гаргаж, багаар ажиллах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны зорилтуудаа дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Халдварт цар тахал шинэ болон дахин сэргэж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Сургуулийн өмнөх боловсролд 3-5 настай хүүхдийг хамруулж, 5 настай хүүхэд бүрийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах;
- Цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн орчныг стандартын шаардлагад нийцүүлсэн байх;
- Монголын түүх, хэл, соёл, ёс заншлаа мэддэг, эх орноороо бахархдаг төлөвшсөн ухаалаг иргэдийг бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлж, багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгож нийгмийн баталгааг хангах;
- Цахим сургалтыг хөгжүүлэхэд багш нарын оролцоог дэмжиж, цахим хичээл боловсруулан суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлэх;
- Үндэсний Монгол хэл бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвших;
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах, байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах;
- Хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэг нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 768.0 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Мөнгөн хөрөнгө	61,166.8	57,191.8	(3,975.0)
Авлага			
Бараа материал	18,523.7	21,595.3	3,071.6
Үндсэн хөрөнгө	675,774.9	675,910.2	135.4
Нийт хөрөнгө	755,465.4	754,697.4	(768.0)
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	755,465.4	754,697.4	(768.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	755,465.4	754,697.4	(768.0)

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 57,191.8 мянган төгрөг болж 3,975.0 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн зарцуулалттай холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 21,595.3 мянган төгрөг болж 3,071.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 43,735.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, цаашид ашиглах боломжгүй 420.0 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ИТХ-ын 141 дүгээр тогтоолын дагуу акталж данс бүртгэвйл ажиллагаээс хасч, үндсэн үйл ажиллагаанд 40,243.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 763,350.6 мянган төгрөг болж 19,132.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2,506.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, суманд эрх шилжүүлсэн аймгийн хөрөнгө оруулалтаар 10,056.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, өөрийн эзэмшлийн газрыг дахин үнэлүүлж 7,318.0 мянган төгрөгөөр орлого авч, өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашилах боломжгүй 748.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан нь нөлөөлжээ. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 87,440.4 мянган төгрөг бөгөөд 675,910.2 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 387,867.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 42,760.5 мянган төгрөг, нийт 430,628.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин хөлс, НДШ-ийн зардлыг 146,879.1 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 13,557.7 мянган төгрөгөөр, хүүхдийн хоолны зардлыг 12,636.1 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 6,530.0 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 123.9

мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 427.5 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 1,500.0 мянган төгрөгөөр нийт 181,654.3 мянган төгрөгөөр бууруулж, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 1,083.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 250,057.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайланд онд төсөвт 7 удаа зохицуулат хийгдэж улсын төсвөөс 373,459.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 22,672.8 мянган төгрөгийн, оны эхний үлдэгдлээс 61,166.8 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогоос 10,056.4 нийт 467,355.5 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, НДШ-ийн зардлыг 189,297.2 мянган төгрөгөөр,
- Хүүхдийн хоолны зардлыг 13,284.5 мянган төгрөгөөр,
- Урсгал зардлыг 10,056.5 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 567.9 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 4,039.7 мянган төгрөгөөр,
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 52.0 мянган төгрөгөөр нийт 217,297.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн гэх мэт

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 467,355.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 408,773.6 мянган төгрөгийг зарцуулж, 57,191.8 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 408,773.6 мянган төгрөг буюу 87.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 58,581.9 мянган төгрөгөөр, хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>							
Д/д	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1	81605-Эрүүл мэндийг дэмжих	804.80	804.80	-	100.0
		2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	33,565.90	24,422.59	9,143.32	72.8
		3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,613.30	1,613.30	-	100.0
		4	81823-Боловсролын байгууллагын багш	886.80	443.40	443.40	50.0
		5	81834-Боловсролын стандарт сургалт	395,670.10	348,065.08	47,605.02	87.9
		6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	1,654.90	1,654.90	-	100.0
		7	83602-ЗДН хөрөнгө	10,056.5	10,056.5	-	100.0

	8	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	22,672.80	21,282.64	1,390.16	
	9	80233-Хүүхэд хамгаалал	430.40	430.40	-	100.0
Нийт			467,355.50	408,773.60	58,581.90	87.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/мянган төгрөгөөр /				
№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Хүүхдийн хоол	20,281.4	20,281.4	НТШ
Нийт дүн		20,281.4	20,281.4	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад гүйцэтгэгчээр шалгарсан “Номун Сэлэнгэ арвижих” ХХК-тай 2024 оны 04 дүгээр сарын 25-ний өдөр гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн /цаашид Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэг гэх/ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал,

дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн хөрөнгийг орлогоор бүртгэж зарцуулалтад хяналт тавих зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Пийк Ом Аудит" ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанбулаг сумын 2 дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 288,924.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,889.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл 1 удаа;
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 1 удаа;
- Санхүүгийн тайлан 1 удаа;
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 1 удаа;
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт 1 удаа;

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

"Пийк Ом аудит "ХХК нь 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 904 дүгээр албан бичгээр "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" захидлыг тус байгууллагад хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханга ажиллах 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Зөвлөмж	1				
Нийт дүн	1				

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад залруулсан алдаа гараагүй болно.

Аудитаар 2,789.1 мянган төгрөгийн зөрчил илэрч давтан гаргахгүй ажиллах зөвлөмж хүргүүлээ.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үнэ төлбөргүй хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн 2,789.1 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эцэг, эхчүүдээс авсан хичээл,	1	2,789.1					1	2,789.1				

ариун цэврийн хэрэглэлийг орлогоор бүртгээгүй												
Дүн	1	2,789.1					1	2,789.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1				1			
Дүн	1				1			

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	79,690,536.71	78,787,176.95
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	61,166,810.31	57,191,847.55
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	61,166,810.31	57,191,847.55
3121	Төгрөг	61,166,810.31	57,191,847.55
31211	Төрийн сангийн харилцах	61,166,810.31	57,191,847.55
33	АВЛАГА		
35	БАРАА МАТЕРИАЛ	18,523,726.40	21,595,329.40
354	Хангамжийн материал	18,523,726.40	21,595,329.40
3541	Бичиг хэргийн материал	56,500.00	170,450.00
3542	Аж ахуйн материал	16,660,954.40	18,080,254.40
3544	Түлш, шатах тослох материал	1,256,000.00	2,944,000.00
3546	Хүнсний материал	550,272.00	400,625.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	675,774,855.13	675,910,214.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	675,774,855.13	675,910,214.74
392	Биет хөрөнгө	675,748,813.61	667,776,589.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	697,041,022.00	697,041,022.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-38,724,501.20	-50,341,851.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,802,828.30	39,717,328.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	-21,817,724.17	-26,281,669.53
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,124,282.50	7,124,282.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,343,760.40	-3,149,188.52
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,333,333.42	-6,333,333.46
393	Биет бус хөрөнгө	26,041.52	8,133,625.01
39301	Програм хангамж	1,250,000.00	2,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,223,958.48	-1,334,374.99
39303	Бусад биет бус хөрөнгө		7,318,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	755,465,391.84	754,697,391.69
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	755,465,391.84	754,697,391.69
51	Засгийн газрын хувь оролцоо	755,465,391.84	754,697,391.69
512	Хуримтлагдсан үр дүн	755,465,391.84	754,697,391.69
5121	Өмнөх үеийн үр дүн	755,465,391.84	755,465,391.84
5122	Тайлант үеийн үр дүн		-768,000.15
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	755,465,391.84	754,697,391.69



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/А/1850395

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн шилэн дансны мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд 5 мэдээллийг хугацаа хоцроож, зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл 1 удаа;
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 1 удаа;
- Санхүүгийн тайлан 1 удаа;
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 1 удаа;
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт 1 удаа;

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх" гэсэн заалт болон уг хуулийн 6 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй зөрчлийг давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч У.Тэргүүнбаяр, нягтлан бодогч Н.Эрдэнэцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

Б.НАРАНЧИМЭГ

432534182

АЛБАН ШААРДЛАГА, ТӨЛБӨРИЙН АКТЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХУУДАС

А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1. Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Сэлэнгэ аймаг Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	СЭА-2025/183/НА-СТА-ТШЗ
-----------------	---	-----------------	-------------------------

1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит
---------------------------	--	-------------------	-----------------------------

1.5 Албан шаардлага / төлбөрийн актын дугаар	СЭА-2025/183/НА-СТА-ТШЗ	1.6 Огноо	2025.02.24	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/
--	-------------------------	-----------	------------	----------------------------

1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл	Алдаа зөрчлийн товч утга	Өмнөх оны аудитаар өгсөн шилэн дансны мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд 5 мэдээллийг хугацаа хоцроож, зөрчлийг давтан гаргасан байна		
	Алдаа зөрчлийн ангилал	Хууль, тогтоомж зөрчсөн		
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оролдох)	4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол		
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Шилэн дансны тухай хууль	
		Заалт	4.1.3	
Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаал		
	Заалт	4.2.1.9, 4.2.1.11		

1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд	1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд	
	Тухайн байгууллагын дансанд	

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Шилэн дансны цахим сан		2024 он	
			2024 он	

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

№	Аудитын багийн		Хариуцагч			
	Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	Б.Наранчимэг	Аудитор	Алтанбулаг суын 3 дугаар цэцэрлэг	Эрхлэгч	У.Тэргүүнбаяр	99716543
				Нягтлан бодогч	Н.Эрдэнэцэцэг	99286504

4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор	2/25		
2	Аудитын менежер	2/25		

4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
---	--------------	----------	-------	------------

1	Тэргүүлэх аудитор	Ч.Энхтуяа	21/25	
2				

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг	Гарын үсэг	
1	Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын	Огноо		
		Дугаар		
2	Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
3	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн	Огноо	2025.02.24	
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
4	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан	Байгууллагын нэр	Алтанбулаг суын 3 дугаар цэцэрлэг	
		Ажилтны	Овог нэр	Н.Эрдэнэцэцэг
			Албан тушаал	Нягтлан бодогч
5	Албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр	Пийк Ом Аудит ХХК	
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо		